# МОНГОЛ УЛС
# ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 28 өдөр Дугаар А/35 Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Наран багийн 3 дугаар цэцэрлэгийн гадна хашаа шинээр татах ажлыг “Ундрам алт” ХХК хийж гүйцэтгэсэн тул ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

| | |
|---|---|
| Ц.Ганданповрон | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |

Гишүүд:

| | |
|---|---|
| С.Чанцал | -Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын Улсын байцаагч |
| Б.Түмэндэмбэрэл | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Д.Эрдэнэбат | -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн |
| Б.Цолмон | -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн |

Zax A/34 Ch

02 00161

С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга

Ц.Ганцэцэг -3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

А.Алтанхуяг - “Ундрам алт” ХХК-ний захирал

Нарийн бичгийн
дарга: Б.Жамбалдорж -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. “Ундрам алт” ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Т.ЖАРГАЛСАЙХАН